2107	Томилолт, зочны зардал	7,391,300.00	5,098,700.00
210702	Дотоод албан томилолт	7,391,300.00	5,098,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,411,400.00	6,992,072.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,867,400.00	2,243,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,886,400.00	1,627,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	326,100.00	217,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	304,100.00	162,372.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	198,000.00	77,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,644,400.00	2,485,000.00
210807	Газрын төлбөр	185,000.00	179,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,613,300.00	42,787,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,882,800.00	32,415,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,730,500.00	10,371,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,491,900.00	66,974,370.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,491,900.00	66,974,370.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,713,500.00	46,198,920.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,117,300.00	15,117,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,661,100.00	5,658,150.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	140,750,200.00	140,737,271.00
223001	Бусад хөрөнгө	140,750,200.00	140,737,271.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,000,000.00	77,090,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	120,000,000.00	77,090,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,713,446,700.00	2,655,953,708.19
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,723,223,500.00	1,690,330,707.93
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,620,467,700.00	1,587,574,950.93
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	102,755,800.00	102,755,757.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	851,335,000.00	838,688,219.05
320001	Орон нутгийн төсвөөс	851,335,000.00	838,688,219.05
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,863,200.00	14,820,750.00
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,863,200.00	14,820,750.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	123,025,000.00	112,114,031.21
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	113,025,000.00	112,114,031.21
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	10,000,000.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	11,323,022.20
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	28,844,052.26
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	954.00	954.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	137.00	137.00
620001	Удирдах ажилтан	12.00	12.00
620002	Гүйцэтгэх ажилтан	85.00	85.00
620003	Үйлчлэх ажилтан	28.00	28.00
620004	Гэрээт ажилтан	12.00	12.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	674.00	674.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	524.00	524.00
630001	Төрийн өмчит ЕБС	524.00	524.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	150.00	150.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	150.00	150.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	137.00	137.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00

650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	53.00	53.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4.00	4.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	18.00	18.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	35.00	35.00
650010	Гэрээт ажилтан	10.00	10.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	261,042,405.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	261,042,405.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	190,504,648.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,260,817.00
210102	Нэмэгдэл	47,260,817.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,007,333.00
210201	Тэтгэврийн даатгал	6,007,333.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,508,800.00
210401	Бичиг хэрэг	2,049,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,897,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	765,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	725,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,071,500.00
2105	Нормативт зардал	61,502,517.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,784,847.00
210502	Хоол, хүнс	15,307,670.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,410,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,163,280.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,204,800.00
210602	Тавилга	1,668,480.00
210604	Урсгал засвар	3,290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	484,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	278,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	206,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,577,901.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,888,901.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,689,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,537,757.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,007,033.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	67,007,033.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,530,724.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,599,839.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	930,885.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	261,042,405.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	261,042,405.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,161,026.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	246,881,379.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Өлгий сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 40 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Шалгагдагч этгээд, түүний орчин ба дотоод хяналт

Өлгий сумын Засаг дарга нь "Монгол улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай ил тод, тэгш хүргэж ажилгүйдэл, ядуурлыг бууруулах" гэсэн гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хүний хөгжлийн бодлого
- Эдийн засгийн бодлого
- Байгаль орчин ногоон хөгжлийн бодлого
- Засаглалын бодлого зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"

Шалгагдагч этгээдийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Өлгий сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 31.0 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,884.3 сая төгрөгийн 1 хувь буюу 38.8 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 31.0 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлгий сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 169.4 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая.төгрөг/		
Мөнгөн хөрөнгө	76.2	83.9	7.7
Авлага	302.9	304.1	1.2
Урьдчилгаа	0.0	0.2	0.2
Бараа материал	256.4	271.3	15.0

Үндсэн хөрөнгө	6,490.9	6,636.3	145.4
Нийт хөрөнгийн дүн	7,126.4	7295.9	169.4
Нийт өр төлбөр	71.6	25.1	-46.6
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,054.8	7,270.8	216.0
Засгийн газрын хувь оролцоо	7,054.8	7,270.8	216.0
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,126.4	7,295.9	169.4

Эх сурвалж: Өлгий сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 83.9 сая төгрөг болж 7.7 сая төгрөгөөр өссөн нь Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 304.1 сая төгрөг болж 1.2 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн төвийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 271.3 сая төгрөг болж 15.0 сая төгрөгөөр өссөн нь Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,636.3 сая төгрөг болж 145.4 сая төгрөгөөр өссөн нь Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн төвийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,270.8 сая төгрөг болж 216.0 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 126.9 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 491.6 сая төгрөгөөр буюу 14.5 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.5.5 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 28.0 сая, татварын бус орлого 513.1 сая, тусламж санхүүжилтийн орлого 3,686.7 сая, нийт 4,227.8 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

3.5.6 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 22.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хүрал:

- Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу батлагдсан төсвийг зарцуулахаар заасан ч гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас замын хуудасгүй, зарцуулалтын тайлангүйгээр 1.5 сая төгрөгийг шатах тослох материалын зардалд зарцуулсан зөрчилд зөвлөмж өгсөн байна.

- Нягтлан бодох бүртгэлийн тухай 14.2.2 дахь заалтад "Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал тусгана" гэж заасны зөрчин 0.2 сая төгрөгийн татварын авлага дутуу илэрхийлсэн байсныг санхүүгийн тайланд тусгаж залруулга хийлгэсэн байна.

Өлгий сумын Засаг даргын тамгын газар:

- Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6 дахь хэсэгт "Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно", Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх хэсэгт "Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрөөл сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэгт "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасныг зөрчиж сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй 2 ажилтанд 0.7 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгож төрд хохирол учруулсанд төлбөрийн акт тогтоолоо.

Өлгий сумын Эрүүл мэндийн төв:

-Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх хэсэгт "Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрөөл сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэгт "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасныг зөрчиж сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй 1 ажилтанд 1.0 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгож төрд хохирол учруулсанд төлбөрийн акт тогтоолоо.

-Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 зүйлийн 20.1.4 заалтад "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг зөрчиж 2020 онд зарцуулсан 11.7 сая төгрөгийн шатах тослох материалыг санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнасныг тайлант онд хөндий зардлаар бүртгэж үр дүнгийн тайлангийн зардлын дүнг өсгөсөн, 0.6 сая төгрөгийн 266 литр шатах тослох материал зарцуулахдаа замын хуудас хөтлөөгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсан нь алдаа зөрчилд албан шаардлага өглөө.

-Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах" зааврын хавсралтад заасан төсвийн зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 3.7 сая төгрөгийн 4 гүйлгээг хийсэн нь алдаа зөрчилд албан шаардлага өглөө.

-Харилцагч талын гарын үсгээр баталгаажаагүй тооцооны үлдэгдлийн баталгааг үндэслэж 3.3 сая төгрөгийн 4 гүйлгээ хийсэн зөрчилд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Өлгий сумын 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 2/04 дүгээр тогтоолоор 2,663,7 сая төгрөгөөр баталж 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 4/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 49.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,713.4 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,713.4 сая төгрөгийн төсөв баталснаас 1,620.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 102.7 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 851.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 15.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 113.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 10.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 38.0 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,587.6 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 102.7 сая, орон нутгийн төсвөөс 800.7 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 14.8 сая, үндсэн ажиллагааны орлогоос 95.9 сая, нийт 2,639.7 сая төгрөгийг орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,297.0 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 32.9 сая, орон нутгийн төсөвт 26.9 сая, нийт 59.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,624.2 сая төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь 59.8 сая төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 1.0 сая төгрөгийн санхүүжилт дутуу хийгдэж, Эрүүл мэндийн төвийн дансанд 2.8 сая төгрөг үлдэж, Сум хөгжүүлэх сангийн батлагдсан төсвөөс 43.2 сая төгрөгийг дутуу зарцуулж, ЗДТГ нь үндсэн үйл ажиллагааны орлогыг 1.3 сая төгрөгөөр давуулан биелүүлж, Байгаль хамгаалах сангийн дансны үлдэгдэл 16.3 сая төгрөгийг ЗДТГ-т нэгтгэсэнтэй холбоотой байна.

Өлгий сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай 04/01 дүгээр тогтоолд зааснаар Өлгий сумын Засаг дарга тайлант онд 28.0 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 51.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 183.6 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 14.1 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 246.9 сая нийт 261.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 257.5 сая төгрөгийг зарцуулж 3.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Өлгий сумын Засаг даргын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 136, хугацаа хоцроож 19 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын авлага 45.9 сая төгрөг байна. Тухайн авлагын дагуу 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Өлгий сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 5 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 22.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 0.2 сая төгрөгийн 1 зөрчлийг залруулж, 1.7 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 16.0 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 4.8 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ИТХ	2	1.7	1	0.2					1	1.5
2	ЗДТГ	1	0.7			1	0.7				
3	ЭМТ	4	20.3			1	1.0	2	16.0	1	3.3
Дүн		7	22.7	1	0.2	2	1.7	2	16.0	3	4.8

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өлгий сумын Засаг дарга	0	0.0								
НИЙТ		0	0.0								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Б.АВИРМЭД/

2022 оны 03 сарын 22-ны өдөр